



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ**

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 1/82

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 53 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний салбарын хууль тогтоомжийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Б. Насантогтох

-Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Л. Мөнхжаргал

-Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга

И. Лувсанцэрэн

-Бодлого төлөвлөлтийн газрын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн дарга

Ё. Энхтуяа

-Бодлого төлөвлөлтийн газрын Нэгдсэн бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч

С. Ариунбулган

-Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод, аудитын газрын Статистик мэдээ, мэдээллийн сан, захиргааны хэм хэмжээний акт, гэрээний үүргийн биелэлт хариуцсан мэргэжилтэн

Б. Давааням

-Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Түгээх сүлжээний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б. Сүндэръяа

-Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн зохион байгуулагч

2. Хуулийн төсөл, холбогдох бусад бичиг баримтыг боловсруулж, танилцуулахыг ажлын хэсэг /Б. Насантогтох/-т үүрэг болгосугай.



Н. ТАВИНБЭХ

170600265